

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”

Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть L (626)

<https://doi.org/10.22353/ms20255021>

Александр ба Монголчууд^{1, 2, 3}

John Andrew Boyle (Манчестр)

Орчуулсан Ц.Отгонсүрэн 
Б.Отгон

Аугаа Александрын нэр Монголчуудтай холбогдох болсон нь Гог (Gog), Магог (Magog)-ийн иргэдийг Монголчууд хэмээн үзсэнээс үүдэлтэй юм. Ийнхүү үзэхэд “Эхлэл Ном (the Book of Genesis)-д уг эх нь байдаг энэхүү домгийн шинэчилсэн хувилбар голлон нөлөөлжээ⁴. Уг “Эхлэл” Ном⁵-д Магогийг Иафет (Japhet)⁶-ийн хөвгүүдийн нэг хэмээсэн бөгөөд нэрийг нь Гомер (Gomer), Мадаи (Madai) нарын нэрсийн дунд бичжээ. Мадаи (Madai) гэдэг нь Медез (Medes)-ийг хэлж буй бөгөөд Гомер нь Каппадокия (Cappadocia) болон Фрижи (Phrygia)-ийн нутагт байсан гэж

¹ 1978 оны 5-р сарын 11-ний өдөр. Эзэн Хааны Азийн Нийгэмлэгийн гишүүдийн өмнө Ноён Жэрард Клаусон (Gerard Clauson)-ны дурсгалд зориулан уншсан лекцийг хянан засварласан эх.

² БНХАУ, Баруун Хойдын Үндэстний Их Сургуулийн Нийгмийн Шинжлэх Ухааны Сургуулийн профессор Б.Отгон (PhD)-ны удирдсан “*The major project of China’s National Social Science Fund: Translation and Comparative Study of Catalogues of the Mongolian Documents in Russian Collections* (Project No.18ZDA323)” төслийн хүрээнд Македоны Александр III (Аугаа Александр, НТӨ 365-323)-т холбогдох сурвалжууд болон баримт сэлтийн талаар дорно дахины судлаач, түүхч, Британийн эрдэмтэн JOHN ANDREW BOYLE (1916-1978)-ийн бичсэн эрдэм шинжилгээний өгүүллүүдийг орчуулан, зохиогчийн бичсэн он цагийн дарааллаар цуврал болгон хүргэж байгаагийн дөрөв дэх өгүүлэл болох “**Alexander and the Mongols**” (Boyle.J.A, 1979) болно.

³ Эл өгүүллийг орчуулах явцад хийсэн тэмдэглэгээний талаар энд товч тайлбарлая. Үүнд: 1. Сэтгүүлийн техник шаардлагад нийцүүлэн уг өгүүллийн зохиогчийн зүгээс тухайн бичвэрт холбогдох зүүлт, тайлбар хийснийг бүхэлд нь тод хэлбэр (**bold**)-ээр онцгойлон ялгаж, харин орчуулагчийн зүгээс хийсэн тайлбар (монгол, англи)-ыг үндсэн хэлбэр (regular)-ээр бичив; 2. Оноосон нэр тус бүрийг галиглахдаа тухайн нэрийн холбогдох цахим бичвэрт тэмдэглэсэн дуудлагыг баримталсан бөгөөд ард нь хаалт “()”-ны дотор уг эхийг хадгалах үүднээс үндсэн өгүүлэл дэх тухайн оноосон нэрийн язгуур хэлбэрийг хэвээр нь бичиж, зарим нэр хийгээд хэрэг явдлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүссэн судлаачид, уншигчдад зориулан хөл тэмдэглэгээг давхар хийж, холбогдох цахим хаяг болон бусад эх сурвалжийг оруулав; 3. Зарим эх сурвалж буюу зохиолын нэрийг орчуулснаас гадна уг өгүүллийн зохиогч үсгийн налуу хэлбэрээр ялган тэмдэглэсэн хийгээд оноосон нэр болон зарим тодотгол зэргийг том үсгээр тэмдэглэсэн, мөн түүнчлэн догол мөр, хоосон зай үлдээсэн зэргийг тус тус хэвээр нь үлдээв.

⁴ A.R.Anderson. Alexander’s Gate, Gog and Magog, and the Inclosed Nations (Александрын хаалга, Гог, Магог болон Хаагдсан Үндэстнүүд). Cambridge. Mass., 1932. 3-8-р тал.

⁵ Х. 2-р тал.

⁶ Зарим бичвэрт “Жеифет” гэсэн хувилбар байх хэдий ч “Иафет” (*Ариун Библи*, 2013:10); “Эфээт” (*Библи*, 2015:41); “Яапет” (буюу ヤベテ (Yapete)) (*Bilingual Bible*, 1984:10) (The Old Testament) зэргийг харгалзан “Иафет” гэж галиглав.

үзвэл тухайн үед Магог энэ хоёр нутгийн зааг, өөрөөр хэлбэл Зүүн болон Хойд Армен (Armenia)-ийн нутаг дэвсгэрт харьяалагддаг Кавказ (Caucasus)-ийн чанх өмнө нутаглаж байсан хэмээн өгүүлж буй хэрэг аж. Харин Гогийн талаар тэмдэглэж үлдээсэн анхны баримтад “тэрээр “Магогийн нутаг (of land of Magog)-ийн” хүн бөгөөд “ард иргэд⁷, цэрэг дайчид нийлсэн” асар өргөн бүрэлдэхүүнтэйгээр бүгд морь хүлэглэн, бөмбөрцгийн хойд захад байх нутгаасаа ирнэ” хэмээн тэмдэглэсэн талаар Эзэкиэл^{8,9}-д дурджээ. Эндээс үзвэл тэрхүү “Магогийн нутаг” Кавказын өмнө оршдог гэдэг нь ташаа болж таарч байна. Цаашилбал, Гогийн байлдан дагуулал нь НТӨ VIII зууны сүүлээр тал нутгаас эхэлж, Дариалын хавцлаар дайрч, өмнөдөд ирсэн Киммерчүүд (Cimmerians)¹⁰ төдийгүй IX зуунд Дарбанд (Darband)¹¹-ын зам дагуу болсон Скифчүүд (the Scythians)¹²-ийн байлдан дагууллаудын үргэлжлэл гэж зөгнөн бичсэн. Мөн Илчлэл (Revelation)¹³ номд “1000 жилийн дараа Сатан (Satan) шоронгоос суллагдаж гараад дөрвөн зүг найман зовхист сууж буй Гог, Магогийн иргэдийг ятгаж, аян дайнд илгээх элсний ширхэг бүрийн тоотой тэнцэх¹⁴ иргэнийг хураахаар ирнэ” хэмээн өгүүлсэн байдаг.

Хүн төрөлхтөнд аюул нүүрлэж ирэхийн цагт тэндээс зугтан зайлахаас сэргийлж тэдгээр иргэнийг гууль, төмөр хэрмийн цаана хаасан тухай домгийг Иосеф (Josephus)-ийн хоёр бүлэгт тэмдэглэн үлдээсэн байдаг. Нэгд¹⁵ нь Скифчүүдийг Гог,

⁷ 1. Тус улсын байнгын хүн амын тоонд багтах бөгөөд үндсэн хуулиар олгосон бүх эрхийг эдлэх эрхтэй, үндсэн хуульд заасан бүх үүргийг биелүүлэх үүрэгтэй этгээд; 2. Хүн ардын хүндэтгэл нэр; 3. Цэргийн биш хүн ард; 4. [хуучирсан] Улс, аймаг (*Монгол хэлний их тайлбар толь*) буюу <https://mongoltoli.mn/dictionary/detail/52634> гэсэн утгатай хэмээн тайлбарласнаас үзвэл “хүмүүс” гэдгээс бага сага зөрүүтэй ойлголт аж.

⁸ XXXVIII. 1-3-р тал.

⁹ Зарим зохиолд “Иезекиэл”, Библийн монгол орчуулгуудад “Езекиел” (*Ариун Библи*, 2013:933), “Яахизхийл” (*Библи*, 2015:1048), Библийн япон орчуулгад “Эзэкиэл (буюу エゼキエル (Эзэкиэру))” (*Bilingual Bible*, 1984:1516) гэжээ. Гэхдээ <https://en.wikipedia.org/wiki/Help:IPA/Hebrew> болон <https://en.wikipedia.org/wiki/Help:IPA/English> галиглах зарчим дээр тулгуурлан эл үгийг “Эзэкиэл” хэмээн галиглав.

¹⁰ НТӨ VIII-VII зууны үед түүхийн тавцанд гарч ирсэн Ираны уугуул, нүүдэлчин иргэд. <http://www.iranicaonline.org/articles/cimmerians-nomads>.

¹¹ Кавказын жижиг довцог, Каспийн тэнгисийн зааг дахь нарийн хавцлын аманд буюу тэнгисийн баруун эрэгт байрлах Дагистаны эртний хот <http://www.iranicaonline.org/articles/darband-i-ancient-city>

¹² НТӨ VII-IV зууны үед Хар тэнгисийн хойд тал нутагт мандан бадарсан Ираны уугуул, нүүдэлчин иргэд. <http://www.iranicaonline.org/articles/scythians>; Зүүн Ираны хэлээр голлон хэлэлцдэг Евроазийн нүүдэлчид бөгөөд НТӨ IX зуунаас НТ-ын IV зуун хүртэл Баруун болон Төв Евроазийн өргөн уудам талд нутаглаж байв.

¹³ XX. 7-8-р тал.

¹⁴ Тус өгүүлэлд “тоолж барамгүй олон”, “үй түмэн” гэсэн санааг “the sand of the sea” хэмээн зүйрлэн хэрэглэсэн болов уу. Тиймээс зохиогчийн эл санааг хадгалах үүднээс энэхүү “элсний ширхэг бүрийн тоогоор” гэх хэллэгийг Бурхны шашны зохиолуудын монгол орчуулгад ашигласныг харгалзан энд ийн үгчлэн хэрэглэв.

¹⁵ Antiquities of the Jews (Еврейчүүдийн эртний үе). VI бүлэг, 1,1.

Магог гээд, харин нөгөөд¹⁶ нь Александр төмөр хаалгуудаар хаасан, Кавказ орчим¹⁷-д байдаг нэгэн хавцлын талаар өгүүлдэг. Уг домгийн хоёр үндсэн хувилбарын нэг нь Сюүдө Методи (Pseudo-Methodius (эл зохиолыг эх сурвалжаа болгон зохиосон уг Домог хожмоо Александрын Тууж (Alexander Romance)-ийн Барууны шинэчилсэн хувилбарт уламжлагдан үлдсэн))-д, нөгөө нь Александрын тухай Христийн Домог ((the Christian Legend concerning Alexander)¹⁸ (уг Домог нь Александрын Туужийн алдагдсан Араб хувилбарт тус тус тэмдэглэгдсэн бөгөөд Александрын Туужийг эх сурвалжаа болгон бичсэнээс гадна өдгөө Этиоп хувилбарт хадгалагдан үлджээ))-т үлджээ. Одоо Сюүдө Методийг эргэн сөхье. Зохиосон он цаг болон зохиогчийн тоо тодорхойгүй ч лавтайяа НТ 629-636 оны хооронд, хойд Месопотамд бичсэн бөгөөд хүн төрөлхтөнд нүүрлэх аюулыг урьдчилан зөгнөн хүүрнэх Александрын тухай Христийн Домогт Гог, Магогийн иргэд (Хүн үндэстэн (the Huns)¹⁹) хэмээн

¹⁶ Wars of the Jews (Еврейчүүдийн аян дайн). VII бүлэг, 7 болон 4-р талууд. Энэхүү хоёр түүвэр хэсэгт үндэслэн Фистер (Pfister) “Гог, Магогийг нэвтрүүлэхгүйн тулд Александр нэгэн хаалга босгосон тухай энэхүү домог Еврей эхээс уг гарвалтай бөгөөд манай эриний I зуунд Александриад зохиосон энэхүү Еврей домгоос Александрын Хаалганы тухай өгүүлэх, энд дурдан буй бүх хувилбар, мөн Сирийн Христийн Домог (Christian Legend) хүртэл тус тус салбарлан зохиогджээ.” хэмээн үздэг. Андерсоны Александрын Хаалга зохиолын 20-р тал, 1-р мөрийг үзнэ үү. Андерсон өөрөө энэ үзэлтэй санал нийлдэггүй байсан бөгөөд “домгийн элементүүд нь ... Иосефын ...-д байх учиртай. Эдгээр элементүүдийг Иосефын цаг үед эмхэтгэж нэгтгэсэн гэх ул мөр байхгүй. Хэрвээ тийн нэгтгэсэн бол ерөнхийд нь хийжээ гэж үзэх ...”. K. Czeglédy “The Syriac legend concerning Alexander the Great (Аугаа Александрын тухай Сири домог)” АОН, VII, 231-49 (237, n 20) нэртэй зохиолдоо сайтар нягталсны үндсэн дээр Андерсоны зохиолд байгаа маргаантай хэсгүүдийг хүлээн зөвшөөрсөн.

¹⁷ Эл газрыг гол төлөв Дарбанд гэж үзсээр ирсэн бөгөөд хамгийн сүүлд гэхэд René Grousset, Histoire de l'Arménie des origines à 1071 (1071 он хүртэлх Арменийн түүх), Paris, 1949, 109-р талд мөн ийн тэмдэглэжээ. Андерсон (Anderson)-ны бичсэн “Alexander at the Caspian Gates (Каспийн Хаалга орчмын Александр)” өгүүлэл Transactions and Proceeding of the American Philological Association, LIX, 1929, 130-163-р талд хэвлэгдэхээс өмнө “Александр түүхэндээ зөвхөн Каспийн Хаалгатай холбогддог, өөрөөр хэлбэл энэ нь Тегран (Tehran)-аас зүүн өмнөш чиглэсэн, уулсын дундах хавцлын зам юм. Харин Туужид Дарбандын хавцалтай холбогдуулдаг. Гэхдээ Андерсон энэхүү судалгаагаараа Хераклус (Heraclius)-ын цаг үе хүртэл Александрыг Дарбанд орчим байсан тухай домогт тэмдэглээгүй ч эл домгийн уг эхэд Тифлис (Tiflis), Владикавказ (Vladikavkaz)-ын хооронд орших Төв Кавказид байдаг Дариалын хавцалд тэрхүү Хаалгыг барьсан тухай тэмдэглэгджээ” хэмээн үзэж үүнийгээ бараг нийтээрээ хүлээн зөвшөөрч байлаа.

¹⁸ Эл газрыг гол төлөв Дарбанд гэж үзсээр ирсэн бөгөөд хамгийн сүүлд гэхэд René Grousset, Histoire de l'Arménie des origines à 1071 (1071 он хүртэлх Арменийн түүх), Paris, 1949, 109-р талд мөн ийн тэмдэглэжээ. Андерсон (Anderson)-ны бичсэн “Alexander at the Caspian Gates (Каспийн Хаалга орчмын Александр)” өгүүлэл Transactions and Proceeding of the American Philological Association, LIX, 1929, 130-163-р талд хэвлэгдэхээс өмнө “Александр түүхэндээ зөвхөн Каспийн Хаалгатай холбогддог, өөрөөр хэлбэл энэ нь Тегран (Tehran)-аас зүүн өмнөш чиглэсэн, уулсын дундах хавцлын зам юм. Харин Туужид Дарбандын хавцалтай холбогдуулдаг. Гэхдээ Андерсон энэхүү судалгаагаараа Хераклус (Heraclius)-ын цаг үе хүртэл Александрыг Дарбанд орчим байсан тухай домогт тэмдэглээгүй ч эл домгийн уг эхэд Тифлис (Tiflis), Владикавказ (Vladikavkaz)-ын хооронд орших Төв Кавказид байдаг Дариалын хавцалд тэрхүү Хаалгыг барьсан тухай тэмдэглэгджээ” хэмээн үзэж үүнийгээ бараг нийтээрээ хүлээн зөвшөөрч байлаа.

¹⁹ “... Хүннү гүрэн зах нийлсэн бусад томоохон аймгийн холбоодыг гадагш шахан түрж эхэлснээс Төв Азийн дэвсгэр нутгаас хэд хэдэн удаа эртний овог аймгуудын их, бага нүүдэл болж тэдгээр нүүн одогсдын дотор Өрнө зүгт Гүнчүд (гунны) хэмээн нэршсэн (Азийн нүүдэлчдээс гаралтай) Хүннү нар байлцсан бөгөөд Европын тал нутаг, Дундад Азийг дайран, улмаар Ромын эзэнт гүрнийг мөхөөж байсан. Хүннүгийн Атилла хаан, Африкийн эх газар хүрсэн цагаан Хүннү (Эфталит) нар нүүдэлчдийн өвөрмөц соёл иргэншлийг суурьшил иргэдэд түгээн хүргэсэн юм” (Наваан Д, 2018:218) гэжээ. Мөн түүнчлэн дэлгэрэнгүйг <https://www.worldhistory.org/Huns/> болон <https://www.thoughtco.com/impact-of-huns-on-europe-195796> -ээс үзнэ үү.

үздэг)-ийг нутагтаа нэвтрүүлэхгүйн тулд хаалт хийсэн талаар өгүүлэх бөгөөд уг үлгэрийг зарим газар дараах байдлаар хураангуйлан бичжээ. Наран ургах нутаг (the Land of the Rising Sun) (нэр нь тодорхойгүй)-ийн зүг аялсны дараа Александр Армениар дайран умар зүг одож, өмнөд Кавказад хүрчээ. Тэрээр нутгийн иргэдээс “Бидний харж буй энэ ууланд ямар үндэстэн суудаг вэ?” хэмээн асуухад “Хүн үндэстэн, тэдний эзэн хаан нь Иафетийн хөвгүүд болох Гог, Магог, Навал хаад юм ...” хэмээн хариулжээ. Тэдний хэрцгий догшин, зэрлэг бүдүүлэг зан авир, аймшигтай үйлдлүүдийн талаар тэдгээр иргэний хэлснийг сонсоод Александр уулын хавцлыг битүүлж, Гог, Магогийн иргэдийг дотогш нэвтрүүлэхгүйн үүднээс гууль, төмөр хаалга барих зарлиг буулгажээ. Хаалганы дээд талд хожмын цагт Хүн үндэстэн хэд хэдэн удаа халдаж ирэхийг урьдчилан зөгнөсөн нэгэн бичээс үйлдэж, түүнээ сийлүүлсэн бөгөөд “826 жилийн дараа” үнэхээр тийм халдлага болсон аж. Александрын Эринээр мөшгөн үзвэл энэхүү халдлага 514 оны 10-р сарын 1-ний өдөр болсон бөгөөд тэр цагт Сабир (Sabir)²⁰ хэмээх нэрээр танил болсон Хүн үндэстэн Кавказ орчимд халдан оржээ. Тэр цаг хугацаагаар Нөлдек²¹ *Домог*-оо эхлүүлсэн. Тиймээс тэрээр Хүн үндэстний хоёр дахь халдлага “940 жилийн дараа” буюу НТ 629 онд болсон талаар тэмдэглэсэн нь урьдчилан хэлсэнтэй давхцах ч дараагийнх нь хоосон таамаг болон хоцорсон юм. Гэсэн хэдий ч Арменийн түүхч Movsēs Dasxuranci²²-ийн зохиолд тухайн жилд маш өргөн хүрээг хамарсан Хазарын халдлага (Khazar invasion) болсон талаар дэлгэрэнгүй түүх байдаг тухай Czeglédy²³ онцлон дурджээ. Тэрээр мөн “Урьдчилан зөгнөсөн үйл явдлууд үнэхээр тохиолдсон гэдэгт эргэлзэх зүйл үгүй юм” гээд “уг Домог 629 оноос хойш буюу 636 онд Арабууд Месопотамид ялалт байгуулсны өмнөхөн өнөөгийн хэлбэрээ олсон” хэмээн дүгнэсэн байдаг.

Гог, Магог нарыг нэгд Скиф, Алан, Хүн үндэстэн; хоёрт онцгойлон Хойд болон Зүүн Хойноос ирсэн үе үеийн эзлэн түрэмгийлэгчидтэй тус тус адилтгаж үздэг байснаас тэднийг XIII зууны үед хамааруулахын зэрэгцээ Монголчууд гэж үзэх учир зүйн холбогдолтойгоос гадна ийм таамаг дэвшүүлэх ч бүрэн үндэстэй юм. Гэсэн хэдий ч Петр Коместер (Petrus Comester)²⁴ хэмээх XII зууны үеийн зохиолчийн бичсэн *Historica scholastic* зохиолд тэмдэглэснээр Гог, Магогийг “шашны хийгээд улс төрийн итгэл үнэмшлийг нь хязгаарлан, Александрын барьсан хаалганы цаана үлдээсэн Израйлийн Орхигдсон Овгууд (the Lost Tribes of Israel)²⁵, эс бөгөөс Ассири (Assyria)-ийн хаан Шалманисер (Shalmanesser) нутгаасаа албадан гаргаж, Медия (Media) руу хөөсөн Еврей овгийнхны үр хойчис болцгоосон Монголчууд хэмээн, нэг бол адилтгаж, нөгөө бол үгүйсгэх нь гол асуудлыг дагуулдаг. Матию

²⁰ Армен болон Азийн бага үндэстэн рүү чиглэсэн Сабирын халдлагын талаар Arthur Christensen, *L'Iran sous les Sassanides* (Сасанидын Эзэнт Гүрний үеийн Иран), Copenhagen, 1936, 348-р талыг үзнэ үү.

²¹ Theodor Nöldeke, “Beiträge zur Geschichte des Alexanderromans (Александрын Туужийн түүхэнд оруулсан хувь нэмэр)”, *Denkschriften der kaiserlichen Akademie der Wissenschaften, Philosophisch-historische Classe XXXVIII*, 1890, Abhandlung, V, 31-р тал.

²² C.J.F.Dowsett (орчуулав), *Movsēs Dasxuranci, The History of the Caucasian Albanians* (Кавказын Албаничуудын Түүх), London, 1961, 104-6-р тал.

²³ 247-8-р тал.

²⁴ Петр Коместорын тухай Saralyn R. Daly, “Peter Comestor: Master of Histories (Петр Коместор: Түүхийн)”, *XXXII*, 1957, 62-73 талыг үзнэ үү.

²⁵ НТӨ 722 оны үед Шинэ Ассирын Эзэнт Гүрэн (Neo Assyrian Empire)-ний халдлагын дараа Израйлийн Хаант улс (the Kingdom of Israel)-аас албадан гаргасан гэгддэг Израйлийн арван хоёр овгийн арван овгийг ийнхүү нэрлэдэг аж. <https://www.britannica.com/topic/Ten-Lost-Tribes-of-Israel>

Парис (Matthew Paris)²⁶ -ын бичсэн гайхалтай нэгэн зохиолд өгүүлснээр бол “Аугаа Александрын залбиралд дурдсанчлан, Каспийн уулсын дунд хаагдсан тэдгээр Татарчууд, мөн Куманчууд (Cumanians)-ыг Бурхны тааллаар Еврейчүүд өөрсдийнхөө нэг хэсэг хэмээн” итгэцгээдэг байв. Тиймээс Европд, ялангуяа Эзэнт гүрэн (the Empire)-ний харьяат маш олон Еврей иргэн нууцаар уулзалдаж, тэдний дундаас нэг нь гарч ирээд:

“Саботын Эзэн (the Lord of Sabaoth) болсон Алдарт Абрахамын үр сад, ахан дүүс минь ээ, Христийн ёс гэх нэрийн дор хэдэн арван жил Бурхан ...²⁷-ны соёрхол хэмээн худал хуурмаг явдлаар бидний үнэн үйл хэргийг дарж далдалж, үгүй хийж²⁸ ирсэнд өөрсдийн зүгээс хариу болгож, Бурхны шүүлт²⁹-ээр тэднийг гэсгээн цээрлүүлж, өөрсдийгөө чөлөөлөх цаг бидэнд нэгэнт иржээ. Ингэж чадвал хожим Израйлийн гэх тодотголтой зүйл үлдэж магад. Өмнө нь үг хэл, дуу хоолойгоо боомилуулж байсан Израйлийн ахан дүүс маань бүх ертөнцийг өөрсдийнхөө төдийгүй бидний мэдэлд авчрахаар зориг шулуудсан. Тиймээс бидний амссан гашуун хийгээд өнөд үргэлжилсэн энэ зовлон, энэхүү агуу үйл хэрэг нь бидний хувьд урам зориг болохуйц билээ” хэмээн тэднийг ятган сэнхрүүлжээ.

Матию цааш үргэлжлүүлэн:

“Цугласан олон бүгд эдгээр үгийг талархалтайгаар хүлээн авч, тэр даруйдаа өөрсдөө чадахын хэрээр сэлэм, хутга, хуяг худалдаалж буй газруудыг олж, тэндээс бүгдийг нь худалдаж аваад, тэрхүү явуулгаа далдлах зорилгоор торхнуудад найдвартай нуусан. Тэд өөрсдийг нь удирдаж асан Христийн шашны удирдагчиддаа хандан “Татарчууд гэж олонхи нэрлэдэг тэдгээр иргэд үнэн хэрэгтээ Еврейчүүд бөгөөд Еврей хүн л хийгээгүй бол дарс ууна гэж үгүй. Энэ тухайгаа тэд бидэнд хуучилсан бөгөөд биднийг ахан дүүсээ хэмээн санаж, хийсэн дарсаа нийлүүлэхийг биднээс аминчлан гуйсан билээ. Гэхдээ бид хүний үнэргүй тэднийг өөрсдөөсөө зайлуулж, үйлдэх гэж буй тэрхүү хатуу гэсгээл цээрлэлээс нь Христийн шашинтан та бүхнийг аврахыг хүсч, үхэлд хүргэх аюултай 30 торх дүүрэн улаан дарсыг аль болох богино хугацаанд тэдэнд хүргэхээр бэлдсэн” тухайгаа эдгээр Еврейчүүд хэлэв. Тэгээд эрээ цээргүй тэдгээр Еврейчүүдээс ангижирах үүднээс бэлдсэн дарсаа нийлүүлэхийг Христийн шашинтнууд эдгээр Еврейчүүдэд зөвшөөрсөн. Гэсэн хэдий ч эдгээр хэдэн Еврейчүүд Германы захад ирээд, урьдчилан бэлдсэн торхтойгоо гүүр гатлахын даваан дээр тэднээс хураамж төлөхийг гүүрний харуул журмын дагуу шаардсан боловч өөрсдийгөө “энэ Эзэнт гүрэн (үнэндээ бол Christendom)-ний сайн сайхны төлөөх үйл хэрэгт хүчин зүтгэж, өөрсдийн гараар хийсэн дарсаа Татарчуудад хүргэж, түүгээрээ тэдний амийг далдуур хөнөөх даалгавар аваад явж буй” хэмээн шаардлагыг нь эс биелүүлэх санаагаа илтэд бүдүүлгээр илэрхийлэв. Гэсэн ч мөнөөх харуул эдгээр Еврейчүүдийн хэлсэн үгэнд итгэж эс ядаад нэг торхонд нь нүх гаргаж шалгахад шингэн зүйл гоожсонгүй. Тэгээд тэр торхны бүслүүр цагиргийг таслан, торхыг эвдэж онгойлгоод, дүүрэн зэвсэг нуусныг мэдэж, ийнхүү эдний далд явуулгыг илрүүлжээ. Тэр даруйдаа “Та минь ээ, урьд өмнө сонстож байгаагүй нууц явуулга энд болж байна. Иймэрхүү хүмүүс яагаад бидний дунд амьдраад байна вэ?” хэмээн хашхирч бусдыгаа дуудав. Тэд удаж төдөлгүй ирцгээж, харуулыг тойрон ихэд гайхширан зогсоно. Дараа нь цугаар нийлж, бусад торхыг эвдэж онгойлгоод, Кологни (Cologne) загварын

²⁶ J.A.Giles (орчуулав), Matthew Paris's English History, from the year 1235 to 1273 (Матию Парисын бичсэн 1235-1273 оны хоорондох Английн Түүх), London, 1852, I, 357-8-р тал.

²⁷ Зохиогч энэ хэсэгт зай (...) үлдээжээ.

²⁸ Дэлгэрэнгүйг <https://newchristianbiblestudy.org/concept/oppression> -ээс үзнэ үү.

²⁹ Дэлгэрэнгүйг <https://newchristianbiblestudy.org/concept/judgment> -ээс үзнэ үү.

сэлэм, хутгануудыг бариулыг нь авч, завсаргүй чигжсэн байхыг олж үзэв. Тэд ийнхүү өөрсдийн нь дунд амьдарч, хууль бус бараа тэвэрлэх замаар өөрсөдтэй нь харилцах боломжийг олгосон тэр Христийн шашинтанд тусална гэхээсээ илүүтэйгээр эдгээр Еврейчүүдийн өөрсдийнх нь хэлсэнчлэн зэвсгийн хэрэгцээ асар их байгаа харь элгийнхнийг зэвсгээр хангахыг зорьсон энэхүү далдалсан үйл ажиллагаа, хэний ч санаанд оромгүй ийм заль мэхийг илчилжээ. Тэгээд эдгээр Еврейчүүдийг шоронд хорих, эс бөгөөс зөөвөрлөж авчирсан зэвсгээр нь хороох ял оногдуулахаар тэр даруйд олон нийтийн хэрэг шийтгэгчдэд хүргүүлж, тушаасан” хэмээн хэлжээ.

XIII зууны сүүлийн 20 гаруй жилийн турш Багдадад үлдэж хоцорсон Монголчуудтай холбоо харилцаатай байсан Доминикан улсын элч Риколдо да Монте Крос (Ricoldo da Monte Croce)-д тэдний уг гарвалын талаар таамаглал дэвшүүлсэн нэгэн сонирхолтой баримт³⁰ байсан. Уг баримтад дурдсанаар, тэдгээр иргэнийг Израйлийн “Орхигдсон Овгууд” гэж олонхоороо үздэг бөгөөд тэдний долоог нь Ассирийн хаан Тиглат Пелесер (Tiglath Peleser) олзолж, Каспийн уулс³¹ хэмээн олны хэлж заншсан Медес (Medes)-ийн уулсын чанадад байх Гозан мөрөн (the river of Gozan)-ий орчим суурьшуулжээ. Хэрвээ Халдейчууд (the Chaldees) болон Ассирчууд (the Assyrians), мөн түүнчлэн Медес болон Персийн ноёрхол тогтох аваас тэд бүх нийтээрээ дагаж мөрдөх зарлиг, тушаалд захирагдаж, тэндээс гарч чадахгүйд хүрнэ. Хаант засаглал Грекчүүдийн гарт шилжих үед Александр өөрөө гардан гайхалтай шийдэл гаргаж уулсын хоорондох хавцлыг битүүлэн тэндээс гарах замыг нь хаажээ. Гэхдээ Жосеф, Методи³² нарын өөрсдийнх нь хэлсэнээр бол хүн төрөлхтөнд аюул нүүрлэж ирэхийн цагт тэд хоёул буцаж ирээд, тэдэнд хатуу гэсгээл цээрлэл³³-ийг хүртээх болно. Тиймээс уулнаас бууж

³⁰ J.C.M. Laurent, *Peregrinatores Medii Aevi quartuor*, Leipzig. 1873, 119-р тал.

³¹ Коместор (Comestor)-ийн бичсэн дээр үндэслэн (Александрын Хаалга, 64-р тал, Андерсоны эш татсан): “... et obsedit [sc. Shalmaneser] Samariam tribus annis, et cepit eam anno novo Osce et sexto Ezechiae, et transtulit Israel in Assyrios, scilicet septem tribus quae remanserant, et posuit eos juxta fluvium Gozan ultra montes Medorum et Persarum” буюу II Хааны эхэд эрх чөлөөний талаар дурдсан бөгөөд XVII. 5-6-р талыг Жон Греи (John Gray, *I and II Kings: a commentary*, 2-р хэвлэл, London, 1970, 642-р тал: “... гурван жилийн турш үүнийг бүслэн авлаа. Хошиа (Hoshea)-ийн есдүгээр онд Ассир (Assyria)-ын хаан Самаар (Samaría)-ыг эзлэн авч, Израйл (Israel)-ыг Ассир руу хөөн, Гозан гол (river of Gozan)-ын эрэг, Медия уулс (the mountains of Media)-ын дунд орших Хала болон Хабур бүс нутаг (Halah and Habor region)-г суурьшуулав.”)-ийн хувилбартай харьцуулснаас харж болох юм. Эл өгүүлбэрийн талаарх тайлбарыг Gray, 643-4-р талаас үзнэ үү. Үнэн хэрэгтээ Элбурз (Elburz) уулсын цаад талд хэмээн Коместерийн шилжүүлэн бичсэн Гозан нэрт гол нь Евфрат (Euphrates) мөрний зүүн эрэг, Хабур (Khabur) хэмээх газар юм. Түүний угсаа залгамжлагч Шалманесер (Shalmaneser)-г зориулан Тиглат Пилесер (Tiglath-pileser)-ийг сольсон нь Риколдо өөрөө байсан бололтой.

³² Тэд ямар иргэд болохыг Иосеф огт дурдаагүй бөгөөд Сюдө-Методийн бичсэнээр Александрын босгосон хаалганы цаана хаасан хүмүүст Орхигдсон Овгуудыг оруулаагүй. Энэ талаар Ernst Sackur, *Subyllinische Texte und Forschungen* (Субилийн эхүүд ба судалгаа), Halle, 1898, 4-5-р тал болон Anderson, *Alexander's Gate* (Александрын Хаалга), 47-8-р талаас тус тус үзнэ үү.

³³ Эл өгүүлэл дэх “slaughter” гэх үгийг англи хэлний тайлбар толь бичгээс шүүвэл, “1. Идшэнд хэрэглэх зорилгоор олон тооны мал, амьтны амийг таслах; 2. Нэг дор (ялангуяа дайн тулааны үеэр) хүнийг үй олноор нь хөнөөх” (Oxford University Press, 2010)” гэсэн утгыг тус тус илэрхийлж байна. Харин Библийн тайлбар толь бичиг (<https://newchristianbiblestudy.org/concepts/?st=slaughter>)-ээс мөшгөн үзвэл “Үхлийн дараах гэсгээл цээрлэл, там руу илгээгдэх үйл явц буюу тамд унах” хэмээн тайлбарлажээ. Эндээс үзэхэд энэ үг “хүн, амьтны махан биеийг хороох, хөнөөх” тухайд бус “нүгэл үйлдэгсэд бие барсны дараа сүнс нь тэрхүү ялаа эдлэн гэсгээл цээрлэл хүлээж тамд унах” тухай ойлголтыг илэрхийлэх тул ийнхүү “гэсгээл, цээрлэл” гэх үгийг хоршуулан хэрэглэв.

ирээд дорно зүгт тэрхүү үйлийг хийх иргэд бол Татарчууд гэдэгт олонхи итгэдэг байв. Тэдний энэхүү итгэл үнэмшлийг нотлох хоёр баримтыг гаргаж тавьсны эхнийх нь Татарчууд Александрыг ихэд үзэн ядаж, нэрийг нь хүртэл сонсож үл түвдэнэ; дараагийнх нь, тэд Халдейчуудынхтай тун адил бичиг үсэг (энэ нь эргээд Еврей³⁴-чүүдийнхтэй тун төстэй)-ийг хэрэглэж байсан явдал юм. Гэвч тэд Еврейчүүдийн ёс уламжлалыг огт мэдэхгүйгээс гадна гадаад төрх, зан төлөвийн хувьд Еврейчүүд төдийгүй бусад бүх үндэстнээс ч ялгаатай аж. Өөрсдийгөө Гог, Магогийн үр хойчис гэж үздэг учраас Магоголи (Magogoli)³⁵ гэх үгээс тасалж үүсгэсэн Маголи (Magoli) гэж нэрийддэг байв. Гэхдээ Методийн зөгнөснөөр зэрлэг бүдүүлэг гэгдэх Гог, Магогийн болон бусад иргэдийг төдийгүй олзлогдсон Еврейчүүд³⁶-ийг нэвтрүүлэхгүйн тулд Александр хаалт хийхээс гадна цаг нь болж нөхцөл нь бүрэлдэхэд гарч ирээд хүн төрөлхтөнд хатуу гэсгээл цээрлэлийг хүртээх аж. Тэдгээр иргэнийг Орхигдсон овгийнхон, эс бөгөөс Гог, Магогийн иргэдийн алин болохыг өнөө хир тогтоож чадаагүй л байна. Тодруулбал хэрвээ тэднийг Гог, Магогийн иргэд гэж үзвэл тэдний хооронд төстэй шинж ер үгүй. Тиймээс тэднийг олзлогдсон Еврейчүүдтэй хольж хутгаж үзэлгүйгээр “Мухардсан шийдэл” (“Solucionem relinquo”) хэмээх ганц үгээр Риколдо дүгнэн хэлжээ.

Түүний хэлсэнчлэн, Монголчууд, магадгүй тэдний зарим хэсэг нь Гог, Магогийн үр хойчис гэдгийг шууд үгүйсгэж болохгүй юм. Несторийн номлогчид VII зуунд Зүүн Азид үйл ажиллагаагаа эхлүүлж, идэвхтэй өрнүүлж байсан нь лавтай. Тэднийг Библи төдийгүй Несторийн бүтээл³⁷ болох *Александрын тухай Христийн домог* болон Методийн *Илчлэл* зэрэг зохиолуудыг²² оруулж ирсэн гэдэгтэй маргах хүн гарахгүй биз ээ. Рашид ал-Дин³⁸ зохиолынхоо хэдэн хуудсанд тэмдэглэн үлдээсэн нэгэн Монгол домогт Монголчууд өндөр уулс, шигүү ойгоор хүрээлэгдсэн хөндийд хэдэн зууны турш бүгэж суусны эцэст тэндээсээ хэрхэн гарсан тухай дараах байдлаар тэмдэглэжээ. Тэд их хэмжээний мод, модны нүүрс цуглуулан, төмрийн уурхай байх эгц эргэцгийн бэлд аваачиж хураав. Дараа нь далан үхэр, адуу нядалж, арьс ширээр нь мөн тооны дархны хос тулман хөөрөг хийв. Хураасан мод, модны нүүрсэндээ гал өрдөн, нөгөө далан хос хөөргөө нэгэн зэрэг үлээж, тэр их галд төмрийн хүдрээ хайлуулж урсган, шуудуу гаргаж, түүгээрээ уруудан тал нутаг руу гарцаав.

Дээр дурдсанчлан алдагдсан Араб эхийн үнэмшил сайтай нэгэн орчуулга болох Александрын Туужийн Этиоп хувилбар³⁹-аас өдгөө бид Александрын гар урчууд Хаалга барьж босгохдоо “бод малын арьсыг өвчөөд, хөөрөг хийж, гал гарган, гууль

³⁴ Бичлэгийн монгол тогтолцоо гэдэг нь Арамей хэлнээс гаралтай гэж үзэх нь туйлын оновчтой бөгөөд Риколдо уг баримтыг тэмдэглэсэн анхны Европ хүн болж таарч байна.

³⁵ Gerhard Doetfer, “Der Name der Mongolen bei Rašid ad-Din (Рашид ад-Дины Монгол гэх нэр) CAJ, XIV, 1970, 68-77 (74-5)-р тал” нь уугуул mongghol/mongghal гэх нэрийн Перс хувилбар “Verballhornung”-д Персийн түүхчид moghōl/mōghāl гэсэн хэлбэртэйгээр тэмдэглэжээ.

³⁶ Үнэн хэрэгтэй Anderson “Alexander’s Gate (Александрын Хаалга)” 67-8-р талд дурдсан шиг, Орхигдсон Овгуудын талаар Сюдө-Методи огт дурдаагүй байна.

³⁷ J.A.Boyle, “The Alexander Legend in Central Asia (Төв Азид дэлгэрсэн Александрын Домог)”, Folklore, LXXXV, 217-28, (224-5)-р талыг үзнэ үү. Өмнө дурдсан зүйл, “Naraygen буюу Нарны Хүмүүс”. Altaica Collecta, Wiesbaden, 1976, 131-6 (132-5)-р тал.

³⁸ Sbornik letopisei (Судрын чуулган), I/i, A.A. Khetagurov (орчуулав), Москва - Ленинград, 1952. 153-4-р тал. Мөн түүнчлэн Boyle. “The Alexander Legend in Central Asia (Төв Азид дэлгэрсэн Александрын Домог)”, 222-3-р талыг үзнэ үү.

³⁹ E.A.Wallis Budge (орчуулав), The Alexander Book in Etiopia (Этиоп дахь Александрын Ном), London, 1933, 142-р тал.

төмөр хоёрыг нийлүүлж хайлуулаад, шавар зуурч буй мэт хольж хутгав.”⁴⁰ Энэхүү хөөрөгний талаар уг үлгэрийн Коран хувилбарт дурдсан нь бий. Тиймээс амьтны арьсаар хийсэн энэхүү хөөрөгний талаар *Христийн Домог*-ийн уг эхэд лавтайя онцолсон байх учиртай.

Монгол домогт уг дүр зургийг эсрэгээр нь буюу тодруулбал, өдгөө Гог, Магог болон Александрын нэрс тэнд орхигдсоноос гадна төмөр, гуулин Хаалгыг төмрийн уурхай мэтээр, мөн өөрсдийг нь хааж хориход хэрэглэсэн Александрын аргыг ашиглан Гог, Магог нар уулсын дунд орших, гарахын аргагүй битүү газар ⁴¹-ыг эвдэж тэндээс гарсан хэмээн тус тус бичжээ.

Арменийн лам Хейтон (Hyaton)-ны бичсэн “Дорнод нутгийн түүхийн цоморлог (Flor des estoires de la terre d’Orient)”⁴² нэртэй домгийн хувилбарт өнөөг хүртэл төдийлөн анзаарагдаагүй, уг эхээс зөрүүтэй нэгэн зүйл тэмдэглэгдсэн бөгөөд тэр нь Монголчууд бүгэж байсан хөндийн нэрээр нэрлэсэн “Эргүнэ Хунгийн Домог”-ийг “Хэрэйдийн удирдагч Ван хан ((Ong Khan)-ыг Престер Жонн (Prester John)⁴³ хэмээн Марко Поло үзсэн)-тай хийсэн тулаанд Чингис хаан ялагдал хүлээснийхээ дараа ухарч очсон Балжун гол (магадгүй нуур ч байж болох)-ын тухай түүхтэй хольж хутгаж ирсэн явдал юм. Монголчуудын уугуул нутаг бол (Балжуна гэх нэрээс үүссэн) Бэлжиан (Belgian) нэртэй уулын зүүн бэлээс их далай хүртэл үргэлжлэх бөгөөд тэндээс цааш явах газар үгүй аж. Мөнх тэнгэрийн зарлигийг дагаж, Чингис хаан их цэргээ удирдан мөнөөх их далайн захад хүрэлцэн ирж, тэндээ мориноосоо буугаад, Дорно зүг хандан есөнтөө⁴⁴ өвдөг сөгдөж, бүхэл шөнийн турш мөргөл үйлдэв. Маргааш өглөө тэд ертөнцийг байлдан дагуулахаар өрнө зүг замдаа гарч, тэрхүү далайн зах хөвөө тэр уулнаас холгүй (9 фийт (буюу 2.8м орчим)) болохыг олж мэдсэн” тухай өгүүлдэг.

Уг домгийн Риколдогийн хувилбар⁴⁵-т ялгаатай нэгэн зүйл тэмдэглэгдсэн нь “Татарчууд уулсын цаана хонь хариулж, ан гөрөө хийж суудаг бөгөөд Боети (Boethius)⁴⁶-ийн үзэж байгаагаар Ромчуудын алдар суу ч тэр газар хүрэхээргүй аж. Дотор нь хүн суудаггүй их цайз бүхий тэр газар хүрээд тэндээс цааш тэр уулсыг давахуйя бэрх болно. Гэсэн хэдий ч ирсэн хүмүүс тэнд дөхөж очоод хүн, амьтан (адуу)-ны дуу, дээр нь нэмэгдээд бүрэн дуу сонстох шиг болж тэндээс айн зугтдаг байж. Гэтэл тэр нэг өдөр нэгэн анчин тэнд хүрээд нэг туулай мөнөөх цайз руу ороод, буцаж гарч ирсэнгүйд гайхан араас нь мөшгөсөөр яваад тэдгээр дуу чимээг үнэн хэрэгтээ салхи гаргадаг байсныг олж мэджээ. Тэрээр эхэндээ туулайн араас цайз руу орох эсэхээ шийдэж ядан байтал нэг шар шувуу хаалганы дээр суугаад

⁴⁰ XVIII. 95-р тал.

⁴¹ Зохиогчийн бичсэн “mountain prison” гэх үг нь “ууланд байдаг шорон”-ны тухай өгүүлээгүй харин “уулсын дундах битүү газар” хэмээн орчуулагчийн зүгээс ойлгож, ийн тайлбартайгаар оноов.

⁴² Recueil des historiens des Croisades. Documents Arméniens (Загалмайтны дайны тухай түүхэн цоморлиг. Арменийн баримт)”, II, Парис, 1906, 115- 253 (152-3)-р тал.

⁴³ Балжуна (Baljuna)-ийн талаар Boyle “The longer Introduction to the Zij-i-Ilkhānī of Nasīr-ad-Dīn Tūsi (Zij-i-Ilkhānī of Nasīr-ad-Dīn Tūsi-д илүү дэлгэрэнгүй бичсэн удиртгал), JSS, VIII, 1963, 244-54 (250, n. 1)-р талаас үзнэ үү.

⁴⁴ Есийн тоог Алтайн иргэд ариун дагшин буюу ид шидийн тоо хэмээн үздэг бөгөөд үүнийг дараагийн өгүүлбэрт дурдах “есөн хөл (nine feet)” гэх үгтэй харьцуулж болно. Jean-Paul Roux, “Les chiffres symboliques 7 et 9 chez les Turks non musulmans (Мусулман шашингүй Түрэгүүдийн долоо ба есийн тооны бэлгэдэл)” Revue de l’Histoire des Religions, CLXVIII, 1965, 29-53-р талаас үзнэ үү.

⁴⁵ Laurent, Дурдсан зохиол, 119-р тал.

⁴⁶ Consolatio philosophiae, II 8: “Actate denique Marci Tullii, sicut ipse quodam loco significant, nondum Caucasum montem Romanae rei publicae fama transcenderat...”

гууглав. Мөнөөх анчин “Тэр туулай хоргодох газар хайж ирсэн энэ газар нэг ч хүн суудаггүй. Тэгэхээр нөгөөх шар шувуу л гууглаж буй хэрэг” хэмээн дотроо бодон өөртөө хэлээд, дотогш цайз руу орсноор бодит байдлыг олж мэдээд, нөхдөдөө хэлж, тэднийг дагуулан тэр замаар явсан тухай юм.

Риколдогийн үзэж байгаагаар энэ үлгэрийн хамгийн эртний бичмэл хувилбар, мөн хожуу зохиогдсон хувилбар⁴⁷-г салхиар үлээгдэх энэхүү бүрэн дуу Кавказаас гарах замыг хамгаалсан хэвээр гэдгийг Гог, Магогт сануулах зорилгоор Александрын хийсэн явуулга гэхээс гадна уг домгийн эх хувилбар бидний үед уламжлагдаж ирсэн хийгээд энэ нь *Александрын Тууж* болон *Христийн Домог*-ийн аль нэгний шинэчилсэн хувилбар (зарим нэг хэсэг нь орхигдсон)-т тэмдэглэгдэн үлдсэн эсэх нь эргэлзээ төрүүлэм аж.

Гэвч Александр бээр Гог, Магогийн иргэдийг хааж хорьсон талаар Монголчуудын гарт очсон *Христийн Домог*-т дан ганц тэмдэглэсэн хэрэг биш, тэдний аман зохиолд ч бас уламжлагджээ. Уг *Домог*-т өгүүлснээр Александр “Наран тэнгэрийн цонхоор ордог тэр газар” хүрэхээр дорно зүг зорчиж явах замдаа тэдгээр иргэнтэй санамсаргүй таарахаас өмнө ...⁴⁸. Тэрхүү наран ургах газар гэдэг нь далайн чанадад байдаг. Тэндхийн иргэд наран ургахын үест тэндээс дайжиж, өөрсдийн биеийг далайн усанд далдлах бөгөөд тэр нь нарны туяанд түлэгдэхээс хамгаалж буй хэрэг бололтой. Мөн түүнчлэн наран тэнгэрийн дундуур зорчсоор, тэнгэрийн цонхоор орох тэр газраа хүрнэ. Ийнхүү зорчих замд нь хаа сайгүй сүрдмээр уулс таарах агаад хад асгыг нь ухааж агуй нүх гаргаад тэндээ толгой хоргодон амь зуудаг, наран (тэдний дээгүүр) өнгөрөх үест хүн төдийгүй шувууд хүртэл дайжин мөнөөх агуйдаа нуугдана. Аагим халуун шатахад хад асга нь хагарч бутран, доош унаж, хүн адгуусны алин болох нь үл ялгагдах амьтад дээр буухад тэд тосож авна⁴⁹. Энэ мэтээр наран ургах зүгийн газар төдийгүй тэрхүү агуйн иргэдийн тухай үлгэрийг Коран судар⁵⁰-т “Тэрээр (Дулхарнайн буюу Александр) цааш явж, наран ургах газар хүрэх замдаа наран хүмүүсийн дээр мандахыг олж үзэв. Тэдгээр иргэнд нарнаас халхлах зүйлийг эс өгч өнгөрөв ...” гэж маш товч дурдсан байдаг. Энэхүү үлгэрийг XIII зууны үеийн газарзүйч Яахут⁵¹ задын чулууны уг гарвалын талаар өгүүлэх “Огуз Түрэгийн домог”-ийн хэдэн хуудсанд нэлээд дэлгэрэнгүй бичиж үлдээжээ. Энэ талаар хожим, Монголд 4-р Инносентийн элчин сайдаар томилогдож очсон Жон де Плано Карпинийн бичсэн алдарт зохиолд “Наран ургах газар гэдэг нь Чингис хааны байлдан дагуулсан улсуудын нэг юм” гэжээ⁵². Жорж Пейнтерийн хянан найруулсан хүүрнэл зохиолын харьцангуй бүрэн хэмээн хэлж болохуйц хувилбарт, мөн Винландын газрын зураг⁵³ нэртэй мөнөөх ботид тэрхүү улсад “Naraygen” буюу “Нарны иргэн” гэх монгол нэр өгсөн тухай

⁴⁷ Anderson, Alexander's Gate (Александрын хаалга), 83-5-р тал болон Denis Sinor, “La Mort de Batu et les tromperies mues par le vent chez Herberstein (Бат хааны үхэл ба Герберштейний бүрээ)”, JA, 1941-42, 201-8 (206-8)-р тал.

⁴⁸ Уг эхэд тухайн өгүүлбэр “to the place where the sun enters the window of heaven” гэсэн хэллэгээр төгсөж, ард нь хоосон зай (...) үлдээсэн нь энэ хэллэгийг бүхэлд нь, эсвэл эл хэллэгийн төгсгөл хэсэг болох “the window of heaven (тэнгэрийн цонх)”, болон өгүүлбэрийг бүхэлд нь тайлбарлах гэсэн санааны алин болохыг англи хэлний өгүүлбэрийн бүтэц болон арын өгүүлбэрийн агуулгатай уялдуулан тодорхойлох боломж хязгаарлагдмал тул ийн үлдээв.

⁴⁹ Budge, “The History of Alexander the Great (Аугаа Александрын түүх)”, 148-р тал.

⁵⁰ XVIII, 88-9-р тал.

⁵¹ Boyle, “Turkish and Mongol Shamanism in the Middle Ages (дундад зууны үеийн Түрэг, Монголын бөө мөргөл)”, Folklore, LXXXIII, 1972, 177-93 (187-8)-р тал.

⁵² Christopher Dawson (хянан найруулав), “The Mongol Mission (Монгол элч)”, London, 1955, 24-5-р тал.

⁵³ R.A.Skelton, Thomas E. Marston, and George D.Painter, The Vinland map and the Tartar relation (Винландын газрын зураг ба Татарчуудын харилцаа), New Haven, 1965, 64,66-р тал.

тэмдэглэжээ. Уг нэрийн “Nara” гэдэг нь Наранд өгсөн татар нэр, харин “Irgen” гэдэг нь “Иргэд” гэсэн утга бүхий аж. Энэ нэр дараах хоёр шалтгаанаар сонирхлыг ихэд татдаг. Үүнд: 1. Карпини болон түүнийг дагалдан явагчид уг үлгэрийг (Орос, Түрэгийн бус) Монгол мэдээлэгчдээс авч оруулсан бөгөөд Христийн Домогт нэмж оруулсан үндсэн сурвалж хэмээн үздэг. Мөн түүнчлэн үүнийг IV зууны эхээр шашны үзэл баримтлалын учраар хороогдсон Патарагийн хамба (bishop of Patara), гэгээн Методийн гар бичмэлүүдэд тэмдэглэгдэн үлдсэн “Методийн Илчлэл” нэрээр алдаршсан, хүн төрөлхтөнд нүүрлэх аюулыг урьдчилан зөгнөн бичсэн зохиол гэдэг. Он нь одоогоор тодорхойгүй боловч лавтайяа 670-686 оны хооронд⁵⁴ Сири улсад Сири хэл⁵⁵-ээр эл зохиолын бичжээ. Харин Мерөвинжиан үе (Merovingian times)-д Латин хэлнээ орчуулсан энэхүү зохиол дундад зууны туршид Европ даяар баримталдаг загвар болж явсаар өнөөгийн бидний үед уламжлагдан ирсэн байна. Уг зохиолд Усан галав⁵⁶-аас хойш 100 жилийн дараа төрсөн, Ионит (Ionitus)-ыг эцэг Ноа нь Дорно зүг хэрхэн илгээж, наран ургах газар⁵⁷ байх нарны бүс нутаг болох Хилию Чора (Hiliu Chora⁵⁸)⁵⁹ гэдэг далайн чанад дахь нутагт нэвтрүүлсэн, Иафетийн үр хойчсын нутаг болсон эл газар Александр хэрхэн хүрэлцэн очсон болон тэнд аймшигтай дүр төрхтэй зэрлэг бүдүүлэг иргэд суудаг талаар олж мэдсэнээс гадна тэднийг умар зүг илгээж, өөрийн хийсэн төмөр, гуулин хаалганы цаана хаасан, тэдгээр иргэдийг Гог, Магогийн хүмүүс⁶⁰ хэмээн үзэхэд хүргэсэн талаар өгүүлдэг. Миний бодоход тэдгээр Нараиргэн (Narayrgen) буюу Нарны иргэд (the Men (People гэх нэрээс илүү тохирох учраас) of the Sun)-ийн нутгийг Сюүдө Методи (Pseudo-Methodius)-д дүрсэлсэн *нарны бүс нутаг* гэж үзэхэд бага сага эргэлзээ төрж байна. Мөн Александрын тухай Христийн Домогийн нэгэн адилаар *Ичлэлүүд*-ийг Несторын номлогчид дорно зүг аваачсанаар Түрэгийн зуучлагчид үүнийг цааш дамжуулсан нь эргэлзээгүй бөгөөд ингэснээр Монголчуудын уламжлалд нэвтрэх болсон гэж таамаглах бүрэн боломжтой болж байна. Александрын тууж нь Христийн зохиол бүтээлүүдийн дараа Зүүн Азид орж ирсэн бололтой гэсэн нэгэн сонирхолтой баримт бий. Үнэн хэрэгтээ, Александр бол Дулхарнайны дүрээр Коран сударт гардаг бөгөөд өвөг Муслим (a proto-Muslim)-ын хэмжээнд хүрсэн ганц хүн нь юм. Уг Тууж (the Romance)-ийн Дорнын хувилбар буюу Туужийн алдагдсан Араб хувилбар болох Сири орчуулга, мөн түүнчлэн уг Сири орчуулгаас эхтэй олон Муслим (Muslim) хувилбаруудад Төв Азиар дайран Хятад⁶¹-д хүрсэн Александрын аяллын талаар бичсэн тэмдэглэл бий.

⁵⁴ Sackur, Дурдсан зохиол, 45-51-р тал.

⁵⁵ Michael Kmoskó, “Das Rätsel des Pseudomethodius (Сюүдө-Методийн Онъсого)”, Byzantion, VI, 1931, 273-96, (275)-р тал.

⁵⁶ Ариун Бичээс Нийгэмлэгээс “Зөвлөх багийн санал ёсоор шинэ хянан засварласан стандарт хувилбар (NRSV)-ыг баримжаа болгон (*Ариун Библи*, 2013)” орчуулсан “Ариун Библи”-д “Их Үер” гэж орчуулсан (*Ариун Библи*, 2013:7). Харин Монголын Библийн Нийгэмлэгээс “«Хуучин гэрээ»-ний номуудыг орчуулахдаа МЭ 500-1000 оны үед Масоретуудын хэрэглэж байсан еврей хэлний текстүүдийг үндэс болгон (*Библи*, 2015:10)” орчуулсан “Библи”-д ийнхүү “Усан галав” (*Библи*, 2015:39) гэснийг дагав. Учир нь “«Усан галав» гэдэг нь “Ертөнц тогтох буюу сөнөх нь усан галавт тохионо” (*Монгол хэлний их тайлбар толь*) буюу <https://mongoltoli.mn/dictionary/detail/22330>” гэсэн тайлбартай холбогдуулан үзэв.

⁵⁷ Sackur, 63-4-р тал.

⁵⁸ “Land of Sun” буюу “Наран ургах газар”. Дэлгэрэнгүйг <https://www.jstor.org/stable/pdf/1509495.pdf> -ээс үзнэ үү.

⁵⁹ Өөрөөр хэлбэл *πλίου χώρα*.

⁶⁰ Sackur, 72-5-р тал.

⁶¹ W.Heissig ба бусад, Tractata Altaica Denis Sinor Sexagenario optime de rebus Altaicis merito deicata-д багтсан Boyle, “Alexander and the Turks (Александр ба Түрэгүүд)”, 1976, 107-17 (107-8)-р тал;

Тэнд хүрэхийн тулд Александр Түрэгүүдийн нутаг дэвсгэрээр дайрах зайлшгүй шаардлагатай байсан агаад угтаа бол XI зуунд зохиосон Кашгарын Түрэг - Араб хэлний толь бичгээс бид Түрэг⁶²-үүдийн дунд өнгөрөөсөн Александр (буюу Дулхарнайн)-тай холбоотой хэрэг явдлуудын талаарх мэдээ баримт, тайлбар сэлт олныг олж авсан. Тэдгээр нь гол төлөв Түрэг овгийнхны нэрсийн талаар шинжлэх ухаанчаар тайлбарласан үлгэр бөгөөд Александрын Туужийн Түрэг хувилбарын салшгүй хэсэг болж, аман болон бичмэлийн аль нэг хэлбэрээр, магадгүй аль алианаар ч өнөөгийн Төв Азид тархсан гэж ойлгох бүрэн үндэстэй аж. Тэр мэт хувилбараас төрсөн санаа сэдэл нь Түрэг, Монголчуудын дунд алдартай уран зохиолд шингэх болсон. Сонирхол татахуйц нэгэн баримт Монголын байлдан дагууллын тухай өгүүлэх Карпинийн тэмдэглэлд бий. Тухайлбал, *Татарчуудын харилцаа*⁶³ зохиолд тэмдэглэсэн харьцангуй бүрэн гэж тооцогдох хувилбараас эш татъя. Чингис хааны хоёрдугаар хөвүүн (буюу Өгөөдэйн удирдсан цэрэг бололтой) Бага Энэтхэг (Lesser India)⁶⁴ буюу Этиопыг эзлээд, дараа нь Их Энэтхэг (Greater India)-ийг шууд дайлсан бөгөөд “хааныг нь Престер Жон⁶⁵ ...⁶⁶ гэдэг. Тэр хаан өмнө нь огт сонстож байгаагүй цоо шинэ зэвсэг хэрэглэн Татарын эсрэг цэргээ хөдөлгөв. Тэд нэгэн өвөрмөц аргыг хэрэглэн, 3000 цэргийн хүчээр дайрсан бөгөөд ингэхдээ төмөр болон хүрлээр ховд⁶⁷ хийж, түүнийгээ эмээлийн бүүрэгний өмнө байрлуулаад, мөнөөх ховдны доторх хөндий зайд гал асааж, Татаруудын татсан сумнаас урьтаж, тэдний эсрэг өөрсдийнхөө галт сумыг тавина. Ингэхдээ галаа хөөргөөр үлээж асаах агаад гуяныхаа дотор талыг дагуулан эмээлийнхээ хоёр талаар унжуулан авч явдаг байв. Ийнхүү галаа асааж сумаа тавихад Татарчууд бужигналдаж эхэлнэ”. Энэ мэтчилэн өөр хоорондоо зөрүүтэй элементүүдийг эл үлгэрт хольж хутган оруулсан байдаг. Тухайлбал, Порусын заан (Porus's elephants)-уудыг хөнөөхөд хэрэглэсэн Александрын аргыг ашиглан Энэтхэгчүүд Монголчуудын эсрэг дайтсан⁶⁸ гэдэг бөгөөд энэ аргыг уг Тууж (the Romance)-д:

“Александр цэргүүддээ барьж буй хүн дүртэй хүрэл ховдуудыг бүгдийг нь гал адил улайтгаж, тэдгээр амьтад⁶⁹-ын өдөөс босгож барихыг тушаав. Тэдгээр амьтад дайрч ирээд, мөнөөх хүн дүртэй хүрэл ховдыг барихад тэдний хошуу ам шатаж, дараа нь тасардаг. Ингэснээр тэд хэн нэгэн рүү дайрна гэж үгүй. Энэ мэт уран цэцэн арга хэрэглэн, ухаан төгс Александр тэдгээр амьтны дайрахыг зогсоож чадсан ажээ.” хэмээн бичжээ.

Мөн тухайн цаг үед Монголчуудын дунд хүмүүсээ олон болгож харагдуулах⁷⁰ үүднээс уулын зай завсар бүрд мануухай босгож тавьдаг заншил байсан талаар тэмдэглэн үлдээсэн бөгөөд энэ нь Парвааны тулаан (the Battle of Parvān)⁷¹ -д бодитойгоор хэрэглэсэн, бодлогын чанартай арга байж болох талтай.

Өмнө дурдсан зүйл, “The Alexander Romance in the East and West (Өрнө Дорно дахинд дэлгэрсэн Александрийн Тууж)”, Bulletin of the John Rylands University Library of Manchester, LX, 1977, 13-27, (16-19)-р тал.

⁶² Boyle, “Alexander and the Turks (Александр ба Түрэгүүд)”, 109-11-р тал.

⁶³ Skelton, Marston, Painter нар, 68-р тал.

⁶⁴ Дэлгэрэнгүйг “The Medieval Expansion of Europe (Phillips J.R.S, 1998:191–194)”-ээс үзнэ үү.

⁶⁵ Дэлгэрэнгүйг “The Medieval Expansion of Europe (Phillips J.R.S, 1998:71)”-ээс үзнэ үү.

⁶⁶ Зохиогч энэ хэсэгт ийн зай (...) үлдээжээ.

⁶⁷ Монгол хэлний их тайлбар толь: 1. Юм агуулах урт нарийн хайрцаг; 2. Сүм хийдэд арц хүж уугиулах онгоц маягийн сав гэж тайлбарлажээ <https://mongoltoli.mn/dictionary/detail/108895>.

⁶⁸ Albert M. Wolohojian (орчуулав), The Romance of Alexander the Great by Pseudo-Callisthenes (Сюдө-Келистенийзийн бичсэн Аугаа Александрын Тууж), New York, 1969, 119-20-р тал.

⁶⁹ Зохиогчийн бичсэн эхийг хэвээр хадгалав.

⁷⁰ Үүнийг Жон де Плано Карпини товч танилцуулсан. Dawson, 36-р тал.

⁷¹ Juvaini, The History of the World-Conqueror (Дэлхийг байлдан дагуулагчдын түүх), J.A.Boyle орчуулав, Manchester, 1958, II, 406 ба n. 40.

Гэтэл Александрын Туужийн Монгол хувилбарт энэхүү улайдсан ховдыг бодож олсон талаар дурдсангүйгээс гадна үнэндээ Порустай дайн хийсэн тухай өгүүлэх хэсгийг бас орхигдуулсан ажээ. Турфан судлалын анхны шинжилгээний ангиас Алберт вон Ле Кох (Albert von Le Coq)-ын авчирч, өдгөө Зүүн Берлиний Шинжлэх Ухааны Академид хадгалж буй нэлээд гэмтэж, тасарсан гар бичмэлд иймэрхүү хэсэг бусаг эхүүд тэмдэглэгдэн үлдсэн бөгөөд эл эхийг Н.Поппе⁷², Ф.Клийвез⁷³ нарын хоёр эрдэмтэн хянан засварлаж, орчуулжээ. “Нэгэн ном⁷⁴-оос үлдсэн ховор нандин хэсэг” хэмээн тодорхойлж ирсэн нийт арван долоон хуудаснаас долоо нь үлдсэн энэхүү товч бүтээл бол Сулхарнай (буюу Дулхарнай - Александр) Сүмбэр уул (Mount Sumur) өөд авирсан нь (i), Далайн гүнд хүрсэн нь (ii), Харанхуйн Оронд хүрсэн нь (iii), Миссир хот руу дайжсан нь (iv) хэмээх үндсэн дөрвөн бүлгээс бүрдэнэ. Эдгээр бүлгийг Профессор Клийвез⁷⁵ судалгааныхаа удиртгал болон уг эхийн орчуулгад дараах байдлаар бичжээ:

“Эрт цагт Миссир (Misr) нэртэй хотод орших Хорасан (Qurasan (X(u)rāsān))-ны нутагт Сулхарнай (буюу Дулхарнай) хэмээх нэгэн эр суудаг байж. Нэг хүн гэнэт гарч ирээд, түүнд хоёр магадгүй гурван мянган жил амьдрах талаар, мөн түүнийг Тэнгэрийн соёрхол хүртсэн хэмээн хэлжээ. Тэдгээр үгийг сонссон Сулхарнай өөрийн ноёд (noyad)-оо дуудаж ирүүлээд “гурван мянган жил амьдрахыг хүсэн ерөөсөн” тухай сонссон бүхнээ тэдэнд дуулгав. Тэрээр дотнын тавин сайн нөхөд (nöked)-ийн хамтаар аяллаа эхлүүлж, гүүр гатлан нэгэн их газар хүрсэн боловч Сүмэр (Sumur (Sumeru)) уул өөд ганцаар өгсөж, ертөнцийг бүхэлд нь тольдон харав. Уулан дээр нэгэн оосор байх агаад түүгээр өөрийгөө уяж, мөнөөх нөхөд (nöked)-ийнхөө нэгнээс сураг ажиг дуулах гэж уулнаас буув. Сулхарнайг ийнхүү уруудаж явахыг Сүмбэр уулан дээрээс харж суусан нэгэн гарди шувуу (Garuda) түүнийг мунхаг болохыг нь хэлж, мөнхийн хутгийг олно гэсэн хүслээсээ татгалзахыг ятгахад тус болохуйц зүйлийг хайж, эргэн тойрныг ажиглана.

Хоёрдугаар бүлгийн хувьд эх нь харьцангуй бүрэн учраас Сулхарнай далайн гүнд хүрсэн тухай өгүүлж буй нь тодорхой аж. Түүнийг далайн гүнд хүрэх бодолтой байгааг ноёд нь сонсоод тоолж барамгүй олон аймшигт амьтадтай таарна хэмээн болгоомжлон, болиулахыг хичээн, хэчнээн ятгасан ч тэдний ятгалгад орох шинж үгүй гэдэг нь түүний царайнаас илт харагдсан тул муу бүхнээс холуур явахыг хүсэхээс өөр зүйл тэдэнд үлдсэнгүй. Тэрээр хоёр хүн багтахуйц хараба (qaraba) барив. Түүний дараа мөнөөх харабагийн гадна талаар тор татаж, 5000 мод газар хүрэхүйц урттай асар олон тооны олс томуулж аваад мөнөөх хараба дотроо хоол хүнс, бусад хэрэгцээтэй эд зүйлсээ ачиж, нэг том чулууг харабадаа сайтар уяж бэхлэн, далайн гүн рүү оров. Энэ нь аль газар болох нь зарим талаараа тодорхой бус ч далайн гүнд хэмээн таамаглаж болох юм. Түүнийг Сүмбэр уул өөд өгсөх замд нэгэн хүн таарч, яриа өрнүүлсэн бололтой. Буцах гэж яаран сандран ахуйд тэрээр усны мандал дээр гарч ирэх бөгөөд далай дотор таарсан ноёдтойгоо хэлэлцэв.

Гуравдугаар бүлгийн эхэнд уг бичвэрийн хэд хэдэн мөр бүрэн бөгөөд Сулхарнай Наран ээжийн зараалаар Харанхуйн оронд очих тухайгаа хэдэн нөхөд (nöked) бас хэдэн ноёд (noyad)-доо хүүрнэж буй тухай өгүүлэх аж. Тодруулбал, Сулхарнай дахин нэг аялалд гарах тухайгаа хэдэн нөхдөдөө дуулгаж, энэ талаар

⁷² “Eine mongolische Fassung der Alexandersage (Александрын түүхийн монгол хувилбар)”, ZDMG, CVII, 1957, 105-29-р тал.

⁷³ “An Early Mongolian Version of the Alexander Romance (Александрын романсын эртний Монгол хувилбар)”, HJAS, XXII, 1958, 1-99-р тал.

⁷⁴ Cleaves, 2-р тал.

⁷⁵ 7-9-р тал.

хэлэлцэх үедээ тэднийг бараа болж явахыг тушаав. Наран ээжийн зараалаар тэд мөнөөх Харанхуйн Орон-ы үүдэнд хүрч ирээд яг орохын даваан дээр нэгэн хүнтэй таарчээ. Тэр хүн Сулхарнайд (уг эхэд ямар нэгэн зүйлийг тэмдэглээгүй хоосон учир зарим үг нь ойлгогдох төдий) нэгэн зүйл учир явдлыг хэлж, түүнийг нь Сулхарнай нөхдөдөө дуулгаад, тэрхүү Харанхуйн Орон-оос буцаж одов. Тэрээр ийнхүү Харанхуйн Орон-ны үүдэнд хүрээд буцсаны учир юу хэмээвээс өөрийгөө хэн гэдгээ мэдэгдэхийг хүсээгүй нэг хүн таарч, аяганд мэлтэлзтэл дүүргэсэн мөнхийн усыг итгэлтэй нь аргагүй түүнд барив. Сулхарнай тэрхүү мөнхийн усыг уугаад 3000 жил амьдрах аж. Энэ тухай тэрээр нөхдөдөө хэлэхэд тэд хариу өгүүллүүн. (тэдгээр үгсийн чухал гэж тооцогдох зарим нэг хэсгүүд нь орхигдсон байна.). Сулхарнай гадагш гарч, нөхдөдөө хандан тэр усыг уухад юу саад болоод байгаа тухай асууж шалгаан, тэдэнд мөнхийн усыг өгөв. Гэвч нөхөд нь хоёр өөр байр суурьтай байлаа. Нэг хэсэг нь уухыг хүссэн ч нөгөө хэсэг нь уух эсэхээ шийдэж эс чадав. Тиймээс нэгэн мэргэн ноён “Би мөнх амьдрахаас айж байна. Энэ бол энэ ертөнцөд ганцаар үлдэж хоцрохоос өөр зүйл үгүй юм” хэмээн түүнд хандан өгүүлжээ. Эл усыг ууж, мөнх амьдрах аваас Сулхарнайг дагах хүн төдийлөн олон байхгүйг тэрээр мөн сануулж, хэрэг тус болохуйц хэдэн үг хэлж, зөвлөгөө өгөв. Сулхарнай одоо элдэв айдас хүйдэсгүйгээр эл усыг уух ч хожим энэ ертөнц дээр цор ганцаар үлдсэндээ харамсан, “хэрвээ энэ усыг уугаагүйсэн бол өөрийгөө ийм нөхцөл байдалд оруулахгүй л байсан байх даа” хэмээн өөртөө хэлэх биз ээ. Сулхарнай тэрхүү билигт сайхан үгсийг сонсоод, оюун ухаандаа тунгаан бодсоны эцэст, мөнөөх усаа гоожуулахад, тэр нь нэгэн модны мөчир дээр бууж, тэр цагаас хойш майлаас мод мөнх ногоон болсон гэдэг.

Дөрөв буюу сүүлийн бүлэгт Сулхарнай эсэн мэнд эргэн ирж, Миссир хотын иргэдэд дуулгаж, тэндээсээ цааш үхэшгүй мөнхийн эрэлд бэдрэн аян замдаа гарав. Ийн зуур хэсэг нөхдөө дуудаж ирүүлээд, аяллаасаа олж авсан мэдлэг туршлагаа хуваалцан, өөрөөс нь өөр тийнхүү баярлаж, догдолсон хүн байсангүй талаар хүүрнэв. Дараа нь тэрээр гэрээслэлээ бичиж үлдээв. Уг гэрээслэлд өгүүлснээр: Түүнийг таалал болсных нь дараа, дэлхийг нэг бүтэн тойруулах бөгөөд мянган гоо охид бүсгүйг авчирч, мянган алтан натур⁷⁶-ыг том жижиг нийлсэн сувд болон алтаар дүүргэн, мянган шилдэг залуу бөх, тамирчин, ятгачин, түүнчлэн хорь, гуч орчим насны идэр залуу хөвгүүд, үсэн буурал мөн тооны настан, бас бус тооны иргэд (жад, сэлэм агссан цэргүүд байж болно)-ийг илгээхээс гадна хоёр мутрыг нь ил гаргаж оршуулах зэрэг багтсан. Энэ хэсэгт ямар нэгэн зүйл тэмдэглээгүй *хоосон зай* байх агаад дараа нь юу гэрээслэн бичиж үлдээснийг мэдэж болохуйц чухал тэмдэглэл орхигджээ. Харин энэ бүлэг Сулхарнай таалал болсон явдлаар төгссөн байна”.

Товч боловч анхаарал татахуйц энэ зохиолд энд бүгдийг багтаана гэхээсээ илүү, уг зохиолын талаар улам гүнзгийрүүлсэн судалгаа бүхий тайлбарыг оруулах нь зүйд нийцэх биз ээ. Клийвес⁷⁷-ийн санал болгосончлон, энэ бол Уйгур-Түрэг эхийн нэгэн орчуулга болох нь эргэлзээгүй бөгөөд уг зохиолыг бичсэн цаг хугацааг ч мөн XIV зууны эхэн үе⁷⁸ гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Уг зохиол агуулгаараа хуучин (уг эх), шинэ (орчуулга) ялгалгүй сонирхлыг татдаг. Александрыг Курашаны уугуул гэж үздэг бөгөөд Поппе уг “Курашан” гэх нэрийг үгчлэхээс зайлсхийж, Дорно

⁷⁶ Клийвесийн тэмдэглэсэнчлэн 94, 405-р тал, өмнө нь тохиолдож байгаагүй энэхүү үг нь нэг төрлийн агуулах савыг нэрлэж буй.

⁷⁷ 27-р тал.

⁷⁸ Cleaves, 4-р тал; Poppe, 105-р тал.

зүг(East)⁷⁹ гэх үгээр орчуулжээ. Тиймээс Төв Азийн Монгол болон Түрэг, Уйгурууд Курашаныг чанх Баруун зүг (the extreme West)-т байдаг улс хэмээн бодож байсан нь тодорхой бөгөөд тэнд Миссир буюу угтаа Александриа хот байжээ. Александр Наран ээжийн зараалаар Харанхуйн Оронд нэвтэрсэн явдал нь Христийн Домог⁸⁰-т өгүүлдэг Шамаш хэмээх Вавилионы Нарны эзэн (the Babylonian sun god Shamash)-ний аяллыг санагдуулдаг. Александрын үлдээсэн гэрээслэлийн “Түүнийг таалал болсны дараа дэлхийг нэг бүтэн тойруулахдаа мянган гоо охид бүсгүйг соёрхол болгож, мянган алтан савыг алт, сувдаар дүүргэн, мянган бөхийг хөгжимчний хамтаар, мөн тооны идэр залуу эр, настан буурлуудыг цугт нь илгээх” талаар өгүүлэх эхний хэсэгт Поппе, Клийвез нарын хэн нь ч ямар ч тайлбар хийгээгүй юм. Энэ бол үнэн хэрэгтээ хүнийг золиос болгосон хийгээд Монгол хаадыг эд зүйлсийн нь хамт бунхалдаг⁸¹ байсан тухай дурдсан явдал бөгөөд Александрыг энд тэдгээр хаантай эн тэнцүү хэмжээнд авч үзжээ. Александрын гэрээслэн үлдээсэн хоёр дахь хүсэл (буюу болзол) бол мутрыг нь ил гаргах явдал бөгөөд өөрөөр хэлбэл тэрээр энэ ертөнцөөс гар хоосон буцсаныг хотол даяараа хараасай гэсэндээ ийнхүү авсанд нь хийлгүйгээр ил үлдээхийг хүсчээ. Энэ үлгэр Амир Хусрау (Amir Khusrau)-ийн зохиосон Аугаа Александр (Ā'ina-yi Iskandarī)-д дурдаагүй ч Бертелийн сүр хүчний талаар Поппе⁸²-ийн баталж буйгаар Аттар (Attār)⁸³ дахь Низами (Nizāmī)⁸⁴-аас гадна Каи Каус бин Искандарын Хабус намэ (Qābūs-nāme of Kai-Kā'ūs b. Iskandar)⁸⁵ болох XI зууны үеийн Хунтайжийн Толь (Fürsten-spiegel)-д тэмдэглэгдсэний зэрэгцээ Александрын Тууж (Alexander Romance)-ийн нэгэн шинэчилсэн хувилбарт багтсан байж болох талтай.

Гарьд шувуу (Garudi bird) болон Сүмүр уулсын талаар дурдсан нь үнэхээр сонирхол татам. Энэхүү гарди шувууны хувьд Энэтхэгийн домгийн шувуу бөгөөд түүнийг Бурхны шашинд үзэшгүй муухай төрхтэйгөөр дүрсэлдэг. Харин эл нэрийг Грекийн үлгэр домогт гардаг Финикс буюу Галт шувуу (Phoenix)⁸⁶-ны орчуулга болгож энд оруулсан болно. Бид энэ талаар Архиприест Найплийн Лео⁸⁷-ийн орчуулсан Александрын Туужийн X зууны үеийн Латин орчуулга болон нарны цацраг адил зүйлийг толгой дээрээ тавиад, навч жимс нь үгүй нүцгэн модон дээр сууж буй нэгэн шувуутай Александр таарсан тухай өгүүлэх VII зууны үеийн Сири хувилбар⁸⁸-аас тус тус уншиж болно. Леогийн өгүүлснээр энэ шувууг Феникс (Fenix) гэх бөгөөд нэр нь үл мэдэгдэх Сири зохиогч “Дал модны шувуу (Palm-bird)” буюу Грек хэлний “Phoenix (Финикс)” хэмээх үгээр ийн нэрлэжээ. Энэхүү бүлэг

⁷⁹ 115-р тал, мөн 1,125-р тал.

⁸⁰ Boyle, “Naraygen (Нарайргэн)”, 135-р тал

⁸¹ H.R.E.Davidson (хянан найруулав), “The journey to the other world (Нөгөө ертөнц рүү хийх аялал)”-д багтсан Boyle, “The thirteen-century Mongols’ conception of the after-life: the evidence of their funerary practices (XIII зууны үеийн Монголчуудын хойд насны талаарх ойлголт: тэдний оршуулгын үеэр үйлддэг ёслолуудын талаарх нотолгоо)”, Cambridge, Ipswich, 1975, 27-41, (28,31, 38, n.7)-р тал.

⁸² 124 болон 123-р тал. Мөн түүнчлэн Cleaves, 26 ба 95-6, болон 428-р талыг үзнэ үү.

⁸³ Musibat-nāma хэвлэл, Nurāni Visāl, Tehran, 1338/1959, 94-5-р тал.

⁸⁴ Iqbāl-nāma хэвлэл, Vahīd Dastgirdī, Tehran, 1317/1938, 259-р тал.

⁸⁵ Reuben Levy (орчуулав), A Mirror for Princes, the Qābūs-nāma by Kai Kā'ūs ibn Iskandar (Каи Каус ибн Искандарын Хабус Намэ буюу Хунтайжийн толь), London, 1951, 136-7-р тал.

⁸⁶ Энэ нь “хэдэн зуун жил амьдраад, дараа нь өөрийгөө шатааж, өөрийнхөө үнснээс дахин амилж төрсөн шидэт шувуу” хэмээн үлгэрт дүрслэгддэг. (Oxford University Press, 2010)

⁸⁷ Fridrich Pfester (хянан найруулав), Der Alexanderroman des Archipresbyters Leo (Архипесбитер Леогийн Александрын Тууж), Heidelberg, 1913, 111-р тал.

⁸⁸ Budge, The History of Alexander the Great (Аугаа Александрын түүх), 101-р тал.

Грек эхэд тохиолддоггүй бөгөөд δ^* уламжлал⁸⁹-д онцгой байр суурийг эзэлдэг. Гэсэн хэдий ч энэ тухай Этиоп хувилбарт дурдаагүй учраас хэдэн зуун өнгөрөөсний эцэст алдагдсан хэсгийг дахин олж авсан. Тиймээс энэхүү товч эхэд асар олон зүйл өөр хоорондоо холилдож, хутгалдсан нь дамжиггүй юм. Энэ Финиксийн талаар Александр уул өөд авирсан тухай өгүүлэх бүлгийн өмнө Лео болон Сири хувилбарт дараах байдлаар анх тэмдэглэсэн байдаг. Үүнд: Александрыг уулнаас бууж ирэхэд Галт шувуу түүнд дөхөж буй дүрслэл нь өөрөө уг β шинэчилсэн хувилбар⁹⁰-т өгүүлсэнчлэн дуганы дээврээс өлгөөтэй алтан торны дотор буй, “тагтаатай адил жижиг биетэй нэгэн шувуу”-аар дамжуулан Александрт хандаж хэлсэн сануулга, анхааруулга юм.

Тэрхүү уулын хувьд (Финикс (the phoenix) гэх) Монгол орчуулагч түрэг хэлний сурвалжаас авсан үг гэхээс илүү Бурхны шашны домогт өгүүлдэг Ертөнцийн төв болсон “Алтан уул” хэмээх утга бүхий Сүмэр (Sumeru (Meru)) гэх Энэтхэг нэрийг өгсөн гэж үзвэл зохилтой. Эл бүлэг β , δ^* хоёр шинэчилсэн хувилбар⁹¹-т байх ч илүү онцлог үйл явдлуудыг Монгол хувилбарт эрс өөрөөр бичжээ. Тухайлбал, уг эхэд алтан гинжийг дээрээс унжуулсан оосор бөгөөд түүгээр дамжин Александр уулнаас буусан⁹² гэснээс гадна Александр тэр нэг сүм рүү орохын тулд уул өөд авирсан бөгөөд тэнд Дионис (Dionysus) бурхны нойрсож буй дүрийг олж харсан хэмээжээ. Харин Монгол хувилбарт түүний уул өөд авирсны гол шалтгааныг Меру (Meru) уулын оройд хүрч, тэндээс ертөнцийг бүхэлд нь тольдон харахыг хүссэн явдал хэмээн үзжээ. Гэхдээ хамгийн ихээр сонирхол татсан бүлэг бол түүний далайн гүнд хүрсэн тухай өгүүлэх хэсэг гэдэгтэй маргах хүн гарахгүй биз ээ. Барууныхан үүнтэй санал нэг бөгөөд тэдний хувьд ч мөн Александрын туужийн эл бүлгээс өөр анхаарал, сонирхлыг хамгийн ихээр татах хэсэг үгүй юм. Тиймээс Профессор Росс (D.J.A.Ross)-ийн “Александр ба Үнэнч бус Хатагтай (Alexander and the Faithless Lady): Усан доогуур хийсэн аялал”⁹³ сэдэвт анхны лекц, онцгойлон дундад зууны үеийн гар бичмэлүүдээс эш авсан хэдэн гайхалтай тайлбарлал руу та бүхний анхаарлыг хандуулмаар байна. Уг үлгэр (story) нь Грек эх⁹⁴-ээс шууд болон дам байдлаар Европод хүрсэн учраас Леогийн хувилбарт ороогүй юм. Сири хувилбарт мөн адил багтаагүй боловч Этиоп хувилбар⁹⁵-т тохиолддог нь цаанаа δ^* шинэчилсэн хувилбартай ямар нэг сэжмээр холбоотой болохыг илтгэж байна. Клийвезийн бичсэн бүтээлд гарсан хараба (qaraba) хэмээх үгэнд тайлбар хийх шаардлагатай. Учир нь түүний анх олж мэдсэнээр⁹⁶, эл үг бол Перс хэлний “хараба (qaraba)” буюу төмөр торон дотор хийсэн асар том хэмжээний улаан дарсны шилэн сав гэсэн утга бүхий англи хэлний “carboy” гэх үг бөгөөд Грек эхэд тэмдэглэсэнээр,

⁸⁹ On the δ^* recension of the Alexander Romance (Александрын романсын δ^* шинэчилсэн хувилбар)-ын тухайд Pfister, 19-24-р тал, Adolf Ausfeld, Der griechische Alexanderroman (Александрын Туужийн Грек хувилбар), Leipzig, 1907, 8, 17-23-р тал; D.J.A.Ross, Alexander historiatus (Александрын Түүх), London, 1963, 4-65-р талаас тус тус үзнэ үү.

⁹⁰ Helmut van Thiel (хянан найруулж, орчуулав), Leben und Taten Alexanders von Makedonien (Александр Македоны амьдрал, үйл хэрэг), Darmstadt, 1974, 155-р тал.

⁹¹ Van Thiel, 155-р тал; Pfister, 111-12-р тал; Budge, “The history of Alexander the Great (Аугаа Александрын түүх), 101-2-р тал.

⁹² Энэхүү Сири хувилбарт дуганыг тойруулсан гинж бий: β шинэчилсэн хувилбарт эл гинжийг дуганы дотор өлгөөтэй хэмээн дүрсэлсэн бол Леогийн тайлбарлаж буйгаар Монгол хувилбарт тэмдэглэгдсэнтэй адил уулын бэл орчмоор өлгөөтэй байсан гэжээ.

⁹³ London, 1967.

⁹⁴ Энэ нь зөвхөн β шинэчилсэн хувилбарт тохиолддог. (van Thiel, 111, 113-р тал).

⁹⁵ Budge, The Alexander Book (Александрын Ном), 169-72-р тал.

⁹⁶ 78, 160-р тал.

Александр тэрхүү шилэн саванд орж, далайн гүн рүү шумбаж орсон гэх илүү үнэмшилтэй тайлбар бий. Энэхүү шумбах хөлөг хүртэлх олсны урт нь 5000 мод буюу 30000 км гүнд хүрэхүйц бөгөөд эл хэмжээ Грек уг эх⁹⁷-д тэмдэглэгдсэн 308 тохой гэсэн хэмжээнээс эрс ялгаатай гэж ойлгож болно.

Александр үхэшгүй мөнхийн эрэлд бэдэрсэн тухай өгүүлэх зохиолын “гол сэдэв (predominant theme)” хэмээн Клийвез⁹⁸ нэрийдсэн бөгөөд эл зохиолд миний зүгээс ямар нэгэн тайлбар сэлт хийсэнгүй. Энэ нь Хадир буюу Хидрийн домог ((legend of Khadir or Khidr) буюу ажлын гараагаа Александрын тогооч (Грекийн далайн бурхан Глаук (the Greek sea-god Glaucus) байж болох юм)-оос эхлүүлж, хэдэн зууныг дамжин, Муслимын зөнч (Muslim prophet)⁹⁹ болтлоо ахиж дэвшсэн Хадир буюу Хидр нэртэй хүний тухай хүүрнэх өргөн цар хүрээг хамарсан сэдэв бөгөөд энд зөнчийн талаар тайлбарлахад цаг багагүй зарцуулахаар байна. Дээр дурдсан бүхэн энэхүү зохиолд багтсан гэж үзээд орхих бус энэ зохиолыг бүхэлд нь анхаарлаа хандуулан судлах хэрэгтэй мэт санагдана. δ* шинэчилсэн хувилбарын Грек уг эх бидний үед хадгалагдаж үлдээгүй ч одоогоор бидэнд байгаа эх сурвалж бол Найплийн Леогийн Латин хувилбар, алдагдсан Араб хувилбарын уг сурвалж¹⁰⁰ болох VII зуунд холбогдох Сири хувилбар болон тэрхүү алдагдсан Араб хувилбараас сурвалжтай Этиоп хувилбар төдийхнөөр хязгаарлагддаг. Энэхүү уламжлалд тулгуурлан зохиогдсон нэгэн шинэ хувилбар бол Александрын Туужийн түүхийг судалдаг эртний Грек, Латин судлалын эрдэмтдийн сонирхлыг татах нь дамжиггүй. Монгол хувилбарын эхийн хадгалалт, хамгаалалт тун эмзэг байдалд байгаа бөгөөд эхийг тайлж унших хийгээд дахин сэргээхэд нэн хүнд нөхцөл байдал тулгарч болзошгүй юм хэмээн Клийвез хэлсэн байдаг¹⁰¹. Хэдий тийм боловч Сюүдө-Келистенийз (Pseudo-Callisthenes)-ийн мэргэжилтнүүдтэй хамтран гэмтэж муудсан энэхүү эхийг засварлан сэргээсэн нь үр дүнгээ өгсөн биз ээ. Гэхдээ эл зохиолын үнэ цэн төдийлөн анзаарагдахгүй байж болох ч, Дулхарнайн гэх Ислам (Islam) нэрээр алдаршсан Александрын талаар дундад зууны үеийн Монголчууд мэддэг байсныг лавтайя гэрчлэх бичгийн баримт болох юм.

Орчуулахад ашигласан хэрэглэгдэхүүн

Bilingual Bible. (1984). World of Life Press.

Boyle, J.A. (1979). Alexander and the Mongols. *Journal of the Royal Asiatic Society of Great Britain and Ireland*, 123–136.

Oxford University Press. (2010). *Oxford Advanced Learner's Dictionary* (8th ed).

Phillips J.R.S. (1998). *The Medieval Expansion of Europe* (2nd ed). Clarendon Press-Oxford.

Ариун Библи. (2013). Ариун Бичээс Нийгэмлэг.

Библи. (2015). Монголын Библийн Нийгэмлэг.

Монгол хэлний их тайлбар толь. (n.d.).

Наваан Д. (2018). *Эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл, дурсамж: II*. МУИС, Монгол Судлалын Хүрээлэн.

⁹⁷ Грек эх (Greek text)-ээс ялгахын тулд Грек уг эх (the Greek original) хэмээн хэрэглэв.

⁹⁸ 7-р тал.

⁹⁹ Israel Friedländer, *Die Chadirlegende und der Alexanderroman* (Чадирын домог ба Александрын Тууж), Leipzig, 1913.

¹⁰⁰ Энэхүү Грек уг эхэд тулгуурлан Араб хувилбарыг зохиожээ.

¹⁰¹ 30-р тал.

Цахим хэрэглэгдэхүүн:

<https://www.britannica.com/topic/Ten-Lost-Tribes-of-Israel>

<https://www.biblestudytools.com/dictionary/tiglath-pileser>

<https://mongoltoli.mn/dictionary>

<http://www.iranicaonline.org/articles/cimmerians-nomads>

<http://www.iranicaonline.org/articles/darband-i-ancient-city>

<http://www.iranicaonline.org/articles/scythians>

<https://www.jstor.org/stable/pdf/1509495.pdf>

<https://newchristianbiblestudy.org/concept/judgment>

<https://newchristianbiblestudy.org/concept/oppression>

<https://newchristianbiblestudy.org/concepts/?st=slaughter>

<https://newchristianbiblestudy.org/concept/vineyard>

<https://www.thoughtco.com/impact-of-huns-on-europe-195796>

<https://www.worldhistory.org/Huns/>